

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/18/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.БАТБУЯН ТАНАА

2022.02.25 № УВА-2022/18/НА-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200254

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/18/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

**2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>167,982,020.72</u></b>	<b><u>287,385,240.53</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	9,531,414.68	10,287,896.69
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	9,531,414.68	10,287,896.69
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,531,414.68	10,287,896.69
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	543,000.00	43,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	543,000.00	43,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	500,000.00	00.00
34714	Томилолтын урьдчилгаа	43,000.00	43,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	157,907,606.04	277,054,343.84
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	157,407,606.04	276,554,343.84
35410	Бичиг хэргийн материал	2,417,000.00	5,033,420.00
35420	Аж ахуйн материал	116,183,301.04	123,172,612.84
35430	Сэлбэг хэрэгсэл	650,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,000,006.00
35450	Барилгын засварын материал	2,393,500.00	28,036,200.00
35470	Бусад хангамжийн материал	35,763,805.00	119,312,105.00
35600	Мал амьтад	500,000.00	500,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,732,894,650.89</u></b>	<b><u>27,272,247,253.95</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,732,894,650.89	27,272,247,253.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,617,211,553.41	27,083,674,703.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,863,351,903.24	7,656,822,025.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,021,212,716.99	-1,278,801,276.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	159,003,200.00	162,419,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-131,372,075.50	-136,795,035.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	258,604,605.72	262,823,733.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-89,796,949.18	-105,050,114.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,672,768.32	62,402,768.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,720,012.92	-26,931,156.52
39209	Зам, гүүрийн байгууламж	00.00	25,703,009,404.81
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-7,454,408,550.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,150,362,491.00	2,383,536,445.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-115,890,490.28	-159,478,070.82
39216	Дуусаагүй барилга, байгууламж	509,000,000.00	14,000,000.00
39217	Ном	208,830.00	125,330.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	115,683,097.48	188,572,550.28
39301	Програм хангамж	6,907,735.88	8,107,735.88
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,880,638.40	-3,931,185.60
39303	Бусад биет бус хөрөнгө	111,656,000.00	184,396,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,900,876,671.61</u></b>	<b><u>27,559,632,494.48</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>504,171.88</u></b>	<b><u>3,751,540.38</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	504,171.88	3,751,540.38
<b>413</b>	<b>Өглөг</b>	504,171.88	3,751,540.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	174,675.88	3,713,540.38
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	329,496.00	38,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	136,250.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	193,246.00	38,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,900,372,499.73</u></b>	<b><u>27,555,880,954.10</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,900,372,499.73	27,555,880,954.10

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	781,010,555.24	781,010,555.24
51101	Өмч: - төрийн	781,010,555.24	781,010,555.24
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,866,540,519.68</b>	<b>26,522,048,974.05</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,866,540,519.68	6,846,866,707.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	19,675,182,266.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	252,821,424.81	252,821,424.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>7,900,876,671.61</u></b>	<b><u>27,559,632,494.48</u></b>

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,963,127,460.00</b>	<b>21,216,738,647.78</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>71,977,235.00</b>	<b>20,054,116,365.78</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>71,977,235.00</b>	<b>20,054,116,365.78</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	71,977,235.00	20,054,116,365.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,956,795.00	2,438,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,020,440.00	20,051,677,965.78
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,891,150,225.00</b>	<b>1,162,622,282.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>755,236,625.00</b>	<b>99,682,982.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	2,270,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	486,501,305.00	88,104,667.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	260,735,320.00	3,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,000,000.00	5,408,315.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,135,913,600.00</b>	<b>1,062,939,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,135,913,600.00	1,062,939,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,056,955,141.04</b>	<b>1,548,379,851.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,431,797,139.04</b>	<b>1,462,115,487.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,263,908,103.04</b>	<b>1,380,816,599.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>599,230,480.00</b>	<b>594,304,735.00</b>
210101	Үндсэн цалин	592,827,820.00	594,304,735.00
210104	Урамшуулал	6,402,660.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,276,915.20</b>	<b>76,817,936.76</b>
210201	Тэтгэврийн даатгал	74,276,915.20	76,817,936.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,524,611.90</b>	<b>90,091,672.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,396,025.00	26,177,370.00
210302	Түлш, халаалт	48,411,100.90	60,474,608.00
210303	Цэвэр, бохир ус	1,717,486.00	3,439,694.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>131,459,411.00</b>	<b>118,669,855.20</b>
210401	Бичиг хэрэг	11,028,240.00	13,730,208.00

210402	Тээвэр, шатахуун	54,133,666.00	53,773,135.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,257,235.00	12,930,869.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,822,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,422,250.00	35,652,566.00
210408	Бараа материал акталсны зардал	2,795,420.00	2,583,077.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,935,500.00</b>	<b>70,894,900.00</b>
210604	Урсгал засвар	33,935,500.00	70,894,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,677,900.00</b>	<b>1,934,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,677,900.00	1,934,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,489,740.00</b>	<b>15,487,886.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,083,100.00	6,950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	504,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211,500.00	229,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,552,000.00	1,345,200.00
210807	Газрын төлбөр	1,428,140.00	6,055,820.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>337,313,544.94</b>	<b>412,615,614.41</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,894,319.00	47,820,854.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,205,600.00	293,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	229,213,625.94	364,501,510.41
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>32,500,000.00</b>	<b>26,500,000.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>16,000,000.00</b>	<b>00.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	16,000,000.00	00.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>16,500,000.00</b>	<b>26,500,000.00</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	16,500,000.00	26,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>135,389,036.00</b>	<b>54,798,887.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>66,006,070.00</b>	<b>23,542,900.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,655,300.00	7,999,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,350,770.00	15,543,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>69,382,966.00</b>	<b>31,255,987.73</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,382,966.00	31,255,987.73
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>625,158,002.00</b>	<b>86,264,364.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>625,158,002.00</b>	<b>86,264,364.00</b>
223001	Бусад хөрөнгө	625,158,002.00	86,264,364.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-93,827,681.04</b>	<b>19,668,358,796.68</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>8,650,000.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	8,650,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>814,458.30</b>	<b>1,826,530.52</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	814,458.30	1,826,530.52
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-814,458.30</b>	<b>6,823,469.48</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-94,642,139.34</b>	<b>19,675,182,266.16</b>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,895,625,020.00</b>	<b>1,165,060,682.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,474,795.00</b>	<b>2,438,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,474,795.00	2,438,400.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	4,474,795.00	2,438,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,474,795.00	2,438,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,891,150,225.00</b>	<b>1,162,622,282.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	755,236,625.00	99,682,982.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	486,501,305.00	87,204,667.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	260,735,320.00	12,478,315.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,000,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,135,913,600.00</b>	<b>1,062,939,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,135,913,600.00	1,062,939,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,253,937,957.00</b>	<b>1,070,856,015.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,253,937,957.00</b>	<b>1,070,856,015.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,086,048,921.00</b>	<b>988,984,127.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	598,290,714.00	593,985,283.86
210101	Үндсэн цалин	515,256,800.00	519,770,637.50
210104	Урамшуулал	6,000,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	77,033,914.00	74,214,646.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	73,920,886.00	77,096,281.41
210201	Тэтгэврийн даатгал	52,550,951.00	55,576,834.57
210202	Тэтгэмжийн даатгал	5,620,893.00	6,033,863.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,175,400.00	4,467,029.36
210204	Ажилгүйдлийн даатгал	956,100.00	999,343.34
210205	Эрүүл мэндийн даатгал	10,617,542.00	10,019,210.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	72,661,497.00	90,209,281.00
210301	Гэрэл, цахилгаан	22,532,916.00	25,040,479.00
210302	Түлш, халаалт	48,411,095.00	61,474,608.00
210303	Цэвэр, бохир ус	1,717,486.00	3,694,194.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>105,453,627.00</b>	<b>79,138,910.00</b>
210401	Бичиг хэрэг	8,725,800.00	9,499,105.00
210402	Тээвэр, шатахуун	55,435,592.00	38,022,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,062,235.00	12,720,869.00
210404	Ном, хэвлэл	333,000.00	394,300.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,770,000.00	1,890,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,127,000.00	16,611,936.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>400,000.00</b>	<b>832,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	832,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>71,757,300.00</b>	<b>87,945,040.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,366,000.00	27,418,690.00
210602	Тавилга	3,700,000.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	36,691,300.00	49,526,350.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,677,900.00</b>	<b>1,934,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,677,900.00	1,934,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,331,940.00</b>	<b>15,487,886.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,925,300.00	6,950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	461,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211,500.00	229,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	42,650.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,552,000.00	1,345,200.00
210807	Газрын төлбөр	1,428,140.00	6,055,820.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>148,555,057.00</b>	<b>42,355,445.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,834,757.00	38,478,315.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,720,300.00	3,877,130.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>32,500,000.00</b>	<b>26,500,000.00</b>
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>32,500,000.00</b>	<b>26,500,000.00</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	32,500,000.00	26,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>135,389,036.00</b>	<b>55,371,887.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>66,006,070.00</b>	<b>24,115,900.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,655,300.00	7,999,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,350,770.00	16,116,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>69,382,966.00</b>	<b>31,255,987.73</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,382,966.00	31,255,987.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>641,687,063.00</b>	<b>94,204,667.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>641,687,063.00</b>	<b>94,204,667.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>641,687,063.00</b>	<b>94,204,667.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>641,687,063.00</b>	<b>94,204,667.00</b>
223001	Бусад хөрөнгө	641,687,063.00	94,204,667.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-641,687,063.00</b>	<b>-94,204,667.00</b>

**2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>781,010,555.24</b>	<b>252,821,424.81</b>	<b>6,866,540,519.68</b>	<b>7,900,372,499.73</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>781,010,555.24</b>	<b>252,821,424.81</b>	<b>6,866,540,519.68</b>	<b>7,900,372,499.73</b>
D01	<b>2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>781,010,555.24</b>	<b>252,821,424.81</b>	<b>6,866,540,519.68</b>	<b>7,900,372,499.73</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-19,673,811.79	-19,673,811.79
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>781,010,555.24</b>	<b>252,821,424.81</b>	<b>6,846,866,707.89</b>	<b>7,880,698,687.94</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	19,675,182,266.16	19,675,182,266.16
D09	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>781,010,555.24</b>	<b>252,821,424.81</b>	<b>26,522,048,974.05</b>	<b>27,555,880,954.10</b>

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,062,939,300.00	1,034,121,712.27	28,817,587.73	97.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,055,939,300.00	1,027,121,712.27	28,817,587.73	97.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,003,823,400.00	976,505,812.27	27,317,587.73	97.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,727,600.00	593,985,283.86	6,742,316.14	98.88
210101	Үндсэн цалин	522,801,200.00	519,770,637.50	3,030,562.50	99.42
210105	Гэрээт ажлын хөлс	77,926,400.00	74,214,646.36	3,711,753.64	95.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,028,300.00	77,096,281.41	3,932,018.59	95.15
210201	Тэтгэврийн даатгал	56,279,100.00	55,576,834.57	702,265.43	98.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,187,300.00	6,033,863.39	153,436.61	97.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,949,800.00	4,467,029.36	482,770.64	90.25
210204	Ажилгүйдлийн даатгал	1,237,500.00	999,343.34	238,156.66	80.76
210205	Эрүүл мэндийн даатгал	12,374,600.00	10,019,210.75	2,355,389.25	80.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,037,100.00	90,209,281.00	827,819.00	99.09
210301	Гэрэл, цахилгаан	12,086,200.00	25,040,479.00	12,954,279.00	207.18
210302	Түлш, халаалт	73,636,000.00	61,474,608.00	12,161,392.00	83.48
210303	Цэвэр, бохир ус	5,314,900.00	3,694,194.00	1,620,706.00	69.51
2104	Хангамж, бараа материалын зардал	79,143,700.00	79,138,910.00	4,790.00	99.99
210401	Бичиг хэрэг	9,147,000.00	9,499,105.00	-352,105.00	103.85
210402	Тээвэр, шатахуун	37,602,400.00	38,022,200.00	-419,800.00	101.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,246,800.00	12,720,869.00	525,931.00	96.03
210404	Ном, хэвлэл	500,000.00	394,300.00	105,700.00	78.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,890,900.00	1,890,500.00	400.00	99.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,756,600.00	16,611,936.00	144,664.00	99.14
2105	Нормативт зардал	832,000.00	832,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	832,000.00	832,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,140,000.00	87,945,040.00	194,960.00	99.78
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,500,000.00	27,418,690.00	81,310.00	99.70
210602	Тавилга	11,000,000.00	11,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	49,640,000.00	49,526,350.00	113,650.00	99.77
2107	Томилолт, зочны зардал	2,309,500.00	1,934,000.00	375,500.00	83.74
210702	Дотоод албан томилолт	2,309,500.00	1,934,000.00	375,500.00	83.74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,065,500.00	15,487,886.00	14,577,614.00	51.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,902,200.00	6,950,000.00	1,952,200.00	78.07
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00	0.00	100.00

210803	Даатгалын үйлчилгээ	461,800.00	461,800.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,000.00	229,216.00	99,784.00	69.67
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	125,200.00	42,650.00	82,550.00	34.07
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,353,700.00	1,345,200.00	8,500.00	99.37
210807	Газрын төлбөр	18,490,400.00	6,055,820.00	12,434,580.00	32.75
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30539700.00</b>	<b>29877130.00</b>	<b>662,570.00</b>	<b>97.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,365,000.00	26,000,000.00	365,000.00	98.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,174,700.00	3,877,130.00	297,570.00	92.87
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>28,000,000.00</b>	<b>26,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>94.64</b>
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>28,000,000.00</b>	<b>26,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>94.64</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	28,000,000.00	26,500,000.00	1,500,000.00	94.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24115900.00</b>	<b>24115900.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,115,900.00</b>	<b>24,115,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,999,900.00	7,999,900.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,116,000.00	16,116,000.00	0.00	100.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,000,000.00</b>	<b>7,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,000,000.00</b>	<b>7,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
223001	Бусад хөрөнгө	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,062,939,300.00</b>	<b>1,065,377,700.00</b>		
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,062,939,300.00</b>	<b>1,062,939,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,062,939,300.00	1,062,939,300.00	0.00	100.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>00.00</b>	<b>2,438,400.00</b>		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,438,400.00		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>60.00</b>	<b>62.00</b>		
620001	Удирдах ажилтан	15.00	15.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00		
620003	Үйлчлэх ажилтан	10.00	12.00		
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00		

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН				
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/ төгрөгөөр /	
			Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>12,478,315.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>12,478,315.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		12,478,315.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	12478315.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		12,478,315.00	

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>87,204,667.00</b>	
2200	Дотоод эх үүсвэрээр		87,204,667.00	
223001	Бусад хөрөнгө		87,204,667.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	99682982.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		99,682,982.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		87,204,667.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,478,315.00	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын нь Эдийн засаг нийгмийн зорилтыг хэрэгжүүлж иргэдийн эрэлт хэрэгцээ хүсэл сонирхлыг бүх талаар хангахад чиглэсэн төрийн үйлчилгээ үзүүлэх Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон Аймаг, сумын ИТХ-ын бодлого зорилтыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах чиглэлээр зохих шийдвэрийг гаргаж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 32,911.2 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,548,379.8 мянган төгрөгийн 2 хувь буюу 30,967.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 24,774.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,389,521.7 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан балансаас балансад шилжүүлж авсан хөрөнгө, бараа материал, хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	9,531.4	10,287.9	756.5
Бараа материал	157,907.6	227,054.3	119,146.7
Үндсэн хөрөнгө	7,732,894.6	27,272,247.2	19,539,352.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,900,876.6</b>	<b>27,559,632.4</b>	<b>19,658,755.8</b>
Өр төлбөр	504.1	3,751.5	3,247.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>7,900,372.5</b>	<b>27,555,880.9</b>	<b>19,655,508.4</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,900,876.6</b>	<b>27,559,632.4</b>	<b>19,658,755.8</b>

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 227,054.3 мянган төгрөг болж 119,146.7 мянган төгрөгөөр өссөн нь ухаалаг худгийн засварын материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,272,247.2 мянган төгрөг болж 19,539,352.6 мянган төгрөг болж өссөн байна. Энэ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор хот тохижилт үйлчилгээний газраас үндсэн хөрөнгө шилжүүлж авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 27,555,880.9 мянган төгрөг болж 19,655,508.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 21,216,738.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,548,379.8 мянган төгрөгөөр буюу 25.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан хангамж бараа материал, хөрөнгийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,103,220.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 40,280.7 мянган төгрөгөөр бууруулж 1,062,939.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,062,939.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,062,939.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,062,939.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,034,121.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,034,121.7 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 99,682.9 мянган төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 138, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар шилэн дансны мэдээллийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзэж байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 21,339.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,061.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 16,126.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоолоо.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасныг зөрчиж Ухаалаг худгийн картын орлого 6,191.1 мянган төгрөгийг авлага дансанд бүртгээгүй, түлш халаалтын зардлаас гарсан 870.0 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд буруу бүртгэсэн алдааг аудитын явцад залрууллаа.

### **4.2 Төлбөрийн акт**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 31.1.2 дахь заалтад “сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, 39.1.3 дахь заалтад “хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг тус тус зөрчин Улаангом сумын Засаг даргын тамгын газар Засаг даргын орлогчийн 1 орон тоон дээр 2 орлогч ажиллуулж 16,126.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаангом сумын ЗДТГ	3	23,187.2	2	7,061.1	1	16,126.1				
	<b>ДҮН</b>	3	23,187.2	2	7,061.1	1	16,126.1				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр